



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: statgreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2025.04.03 № 16

Төсвийн зарлагын хэмнэлт,  
үндсэн үйл ажиллагааны нэмэлт  
орлогын зарцуулалтын талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасан. Үндсэн хуульд заасны дагуу төрийн бүх байгууллага "хууль дээдлэх" зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон дагаж мөрдөх ёстой.

Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах"; "...Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно..." гэж улсын төсөв батлах эрх зүйн зохицуулалтыг тусгасан байдаг.

Засгийн газрын бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-д "...төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" гэж заасан.

Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Сангийн Сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-аар төсвийг захиран зарцуулахаар зохицуулсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан улсын төсвийг Улсын Их Хурлаас батлах зохицуулалттай зөрчилдөх, цаашилбал Улсын Их Хурлын бүрэн эрхийг хязгаарлаж байгаа тул эдгээр зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2-т "...эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах...", 3.2.3.1-т "Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ", Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.1-ийн 2-т "Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна.", мөн тогтоолын 2 дугаар

2025000022

хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 4.1-ийн 4.1.6-т “Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд төсвийн үр ашиг, сахилга бат, хяналт хариуцлага, төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс хууль тогтоомжийн зарчим, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлага, үр дүнд тулгуурлан үйл ажиллагаа явуулах ёстой.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан дараах мэдээллийг шуурхай ирүүлнэ үү. Үүнд:

1.Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Сангийн Сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалын хавсралт “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-аар зохицуулсан төсвийн харилцааны талаарх хууль зүйн үндэслэл, тушаал шийдвэр болон 2022 оноос хойш гарсан зардал тус бүрээр, зардлыг Төсвийн захирагчаар, жил бүрээр холбогдох тайлбарын хамт;

2.Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмын дагуу хяналт шалгалт явуулсан тайлан мэдээг жил бүрээр;

3.Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам зөрчсөн этгээдэд хариуцлага тооцсон талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

4.Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны зарлагын хэмнэлт, нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээг тусгасан санхүүгийн болон үр дүнгийн тайланг 2022 оноос хойш жил тус бүрээр;

5.Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д зааснаар Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, өөрийн орлого, зарлагын хэмнэлт, тэдгээрийн зарцуулалт, гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах, олон нийт, байгууллагын хамт олонд нээлттэй байх шаардлага, нөхцөлийг сүүлийн 3 жилийн хугацаанд Төсвийн захирагчид хуульд заасан хэм хэмжээнд хэрхэн хангасан, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг асуудалд хэрхэн хяналт тавьж, дүгнэсэн талаарх мэдээлэл;

6.Монгол Улсын 2022-2024 онд хамаарах Төсвийн тухай хуулийн 4.1.31-д заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг төлөвлөсөн тооцоолол болон түүний гүйцэтгэлийг харьцуулан, Төсвийн захирагч тус бүрээр мэдээллийг боловсруулан, тайлбарын хамт;

2025000022

7.Төсвийн хуулийн 46 дугаар зүйлээр зохицуулагдаж буй харилцаа нь төсөв, эдийн засаг, салбарын бодлогод хэрхэн эерэг үр нөлөө үзүүлсэн талаарх үндэслэл бүхий тайлбар, цаашид санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд энэ талаар ямар бодлого баримталж байгаа талаарх мэдээллүүд болно.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН